



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ
ГАЗАР

Нийслэлийн засаг захиргааны IV байр,
4 дүгээр хороо, Чингэлтэй дүүрэг,
Улаанбаатар хот, 15160-0066
Утас:(976) 7575 7807, Факс: (976) 7575 7809
Цахим шуудан: contact@ub-procurement.mn
Цахим хаяг: www.ub-procurement.mn

2024.08.26 № 03/1642

танай _____-ны № _____-т

Тодруулгын хариу хүргүүлэх тухай.

Тус газраас 2024 оны 08 дугаар сарын 06-ны өдөр зарласан НХААГ/20240101235 дугаартай 32-ын тойргийн үйлчилгээний барилга, тохижилт ногоон байгууламж (Улаанбаатар хот)-ийн ажилд тендерт оролцохыг сонирхогч этгээдээс цахим системээр тодруулга ирүүлсний дагуу Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.6 дахь заалтын дагуу тендер шалгаруулалтын баримт бичигт дараах өөрчлөлтийг оруулж байна. Үүнд:

№	Оролцогчоос ирүүлсэн тодруулга	Тодруулгын хариу
1	Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ, 19,2-н 4,1д "Ажил гүйцэтгэж дуусах хугацаа нь 2024 оны 12-р сарын 30-ны өдөр байна" гэж заасан нь тендер нээх болон шалгаруулах, хүчинтэй байх хугацаа зэргийг тооцоход ажлын үе шатны графикт дээрх хугацаанд хийж гүйцэтгэх бодит боломж байхгүй байна гэж үзэж байгаа тул энэ хугацааг эргэн харж тодорхойлж өгнө үү.	4.Техникийн чадавх болон туршлагын шалгуур үзүүлэлт, шаардлагыг хангахыг нотлох бусад баримтыг нотлох баримт бичиг: 1. Ажил гүйцэтгэх үе шатны ажлын хуваарийг баталгаажуулан ирүүлэх ба ажил гүйцэтгэж дуусах хугацаа нь 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдөр байна гэснийг 2025 оны 06 дугаар сарын 01-ний өдөр гэж;
2	Тендерийн баримт бичгийн II бүлэг Өгөгдлийн хүснэгтийн ТШЗ 19.1-т ажил гүйцэтгэх хүний нөөц, инженер техникийн ажилтнуудын шаардлага, тоо бүхий хүснэгт, мөн ТШЗ 19.2-т ажил гүйцэтгэх гэрээт буюу хөлсөөр ажиллах хүний нөөцийн гэрээний шаардлагыг тусгаж өгсөн байна. Гэвч хүснэгтэд заасан инженер техникийн ажилчдаас хэрхэн хөлсөөр ажиллах гэрээний дагуу ажиллуулж болох талаар дурдаагүй байх тул ямар мэргэжлийн инженер техникийн ажилтнуудыг гэрээтээр ажиллуулж болох тухай холбогдох тодруулга, тайлбар өгнө үү.	Техникийн чадавх болон туршлагын шаардлага: "Шаардана" 1.Ажил гүйцэтгэх хүний нөөц: "Шаардана" - Тендерт оролцогчийн 50-иас дээш хувь нь үндсэн ажилтан байх ба нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн мэдээллийг цахим системээр дамжуулан шалгана. Бусад ажилтны хөлсөөр ажиллах гэрээг зөвхөн тухайн төсөл, арга хэмжээнд зориулан байгуулсан байх шаардлагатай гэж;

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах

тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-т заасны дагуу тодруулгыг цахим системд нээлттэй байршуулснаар сонирхогч этгээдэд хүргүүлсэнд тооцно.